



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВ.Ю.НИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН  
ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

1. Хотын стандартын хэрэгжилт, цаашид батлуулах 10 бүлгийн 24 хотын стандартын төслийн танилцуулгыг Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1. Хотын стандартын төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн санал авах, хянан тохиолдуулах, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих бэлтгэл хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын үр дүнг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч (П.Сайнзориг)-д;

2. Нийтийн тээврийн салбартай холбоотой хотын стандартын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч (П.Сайнзориг)-д;

3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран хотын стандартыг мөрдүүлэх дараах үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, биелэлт үр дүнг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг (Дүүргийн Засаг дарга нар)-г:

- явган хүн, унадаг дугуйн зам талбайн стандартын хэрэгжилт;
- хүүхдийн тоглоомын талбайн стандартын хэрэгжилт;
- хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй дэд бүтэц;
- нийгмийн дэд бүтцийн стандартын хэрэгжилт;
- худалдаа үйлчилгээний байгууллагын гадна орчны стандартын хэрэгжилт;
- хог хаягдал, ногоон байгуулмж бүлгийн хотын стандартын хэрэгжилт.

4. Хотын стандартыг мөрдүүлэх дараах 4 үе шатны арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх, холбогдох албан хаагчдын стандарт, нормын талаар мэдлэг ойлголт, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагад, хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-г;

Төлөвлөлтийн үе: Тохижилт, бүтээн байгуулалтын ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар, техникийн тодорхойлолт, худалдан авах ажиллагааны бичиг баримт, зураг төслийг боловсруулахдаа холбогдох хотын стандартын хэм хэмжээг нарийвчлан тусгаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (М.Баяраа), Хот байгуулалт, хөгжлийн газар (Д.Хан-Уул), Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг), дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт;

Гүйцэтгэлийн үе: Хот тохижилт, авто зам, замын байгууламжийг барьж байгуулах, засвар үйлчилгээ, нөхөн сэргээх ажил, нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээний

1110200484

гүйцэтгэлийн явцад хотын стандартад заасан хэм хэмжээг мөрдүүлэх, хяналт тавьж зөрчил дутагдлыг тухай бүр арилгаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (М.Баяраа), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан) Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар (Б.Мөнхбат), дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт;

Хүлээн авах үе: Тохижилт, бүтээн байгуулалтын ажил, үйлчилгээг хүлээн авахдаа хотын стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (М.Баяраа), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам), Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар (Б.Мөнхбат), дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт;

Ашиглалтын үе: Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, гудамж, зам, талбай, эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт, засвар үйлчилгээний ажилд холбогдох хотын стандартын хэм хэмжээ, шаардлагыг хангуулахыг холбогдох нийслэлийн нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудад;

5.Хотын стандартын тогтолцоог 2024-2028 онд хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулж 2024 оны I улиралд багтаан танилцуулахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

